



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит - тайлан

Аудитын код: ГАА-2024/227/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunj.dmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэ

Утас: 99175677 Цахим хаяг: erder.ekhimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402. Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.24 № 86

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээд эс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний дуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцолсон хэсэг

Тус байгууллага нь 2023 онд 385 суралцагчид мэргэжлийн болон бүрэн дунд боловсрол олгосон бөгөөд сургууль үүсгэн байгуулагдсаны 60 жилийн ойг зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд улсын төсвөөс 2,094,488.5 мянган төгрөгийн урсгал зардлын, орон нутгийн төсвөөс 574,810.9 мянган төгрөгийн тогтмол зардлын санхүүжилт авсан байна.

07020131

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 хөтөлбөр, 6 зорилт, 39 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 34 арга хэмжээг бүрэн, 3 арга хэмжээг 80.0 хувиар, 2 арга хэмжээг хэрэгжүүлээгүй дундаж биелэлтийг 93 хувиар хүргүүлсэн бөгөөд Боловсролын ерөнхий газраас 87.8 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хэлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилд улах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн ортоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ анд эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭНГҮҮЛЭХ
АУДИТОР

Г.Г. НЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл		/мян.төг/	
	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	573,809.1	619,561.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,413,298.5	2,593,303.8
	Нийт хөрөнгийн дүн	2,987,827.8	3,091,791.3
	Нийт өр төлбөрийн дүн	19,279.9	121,073.9
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,967,827.8	3,091,791.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,967,827.8	3,091,791.3
	Үйл ажиллагааны орлогын дүн	5,557,203.8	2,729,387.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,579,937.8	2,962,914.3
	Үйл ажиллагааны үр дүн	2,977,266.0	(233,527.3)
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	2,977,266.0	(233,527.3)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,438.19)	2,967,827.76
	Тайлант оны үр дүн	2,977,265.96	(233,527.27)
	Эцсийн үлдэгдэл	2,987,827.76	3,091,791.29
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,821,485.6	2,682,230.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,821,310.6	2,678,362.4
	Үйл ажиллагааны ЦМГ	175.0	3,868.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(175.0)	(3,868.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,277,595.70	2,642,742.1
	Урсгал зардал	2,277,420.7	2,638,874.1
	Хөрөнгийн зардал	175.0	3,868.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,277,595.70	2,642,742.1
	Улсын төсвөөс санхүүжих	1,022,706.6	2,050,006.4
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,254,889.1	574,773.3

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 0.9 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгө /принтер, автомат угаалгын машин/ 2.3 сая төгрөгийг бараа материалын дансанд бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан (буруу ойлгосон), хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Залруулагдаагүй нийт 8.4 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их боловч шинж чанарын хувьд материаллаг бус тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 8.4 сая төгрөгийн 5 зөрчил² илэрснээс 0.7 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7.7 сая төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Төлбөрийн акт

1. Ажилтнуудад 0.7 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг байгууллагын даргын тушаалаас илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.10-т "Энэ журмын 4.1-д заасан багш, туслах багш, албан хаагчид улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг тухайн сургалтын байгууллагын эрхлэгч, захирал гаргана", Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 21-ны А/110 дугаар тушаал "Үр дүнгийн нэмэгдэл олгох тухай" гэж заасантай нийцэхгүй үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Тайлант онд үнэ төлбөргүй дээд газраас ирсэн авто тээврийн хэрэгсэлд 3.0 сая төгрөгийн засвар үйлчилгээг хичээл үйлдвэрлэлийн зардлаас хийсэн нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

2. Зардлын эдийн засгийн ангилал зөрчин тэмцээн, уралдаан олимпиадад амжилт үзүүлсэн багш нарт 3.8 сая төгрөгийн шагналт цалинг цалингийн зардлаас олгосон нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр байгууллагын даргын шийдвэрээр төрийн үйлчилгээний 2 албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүлэн 0.8 сая төгрөгийн цалин олгосон нь Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 2-т "Салбарын онцлог, гүйцэтгэлд суурилсан үр дүнг харгалзан үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг цалингийн доод хэмжээнээс нэмэгдүүлэх асуудлыг тухайн жилийн батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд зохицуулж шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй", Засгийн газрын 2023 оны 241-р тогтоолын 2-т "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэ

хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн эрөнхийлөн захирагч нарт даалгасугай"-тай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант оны эцэст ажлын гүйцэтгэлийг үндэслэхгүйгээр захирлын зөвлөлийн ажиллагсдад 60-90 хувиар, бусад ажиллагсдад 10 хувиар тооцож харилцан адилгүй урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэл... "Төсөвт байгууллагын ажилтныг урамшуулах тухай асуудлыг хэлэлцээд төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зохистой удирдаж, зарцуулсантай холбогдуулан 2023 оны төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн Төсвийн тухай хуулийн 46.3.2-т заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагаас бусад байгууллагын цалингийн сангийн хэмнэлтээс ажилтныг ажлын үр дүнг харгалзан үзэж нэг сарын үндсэн цалингийн 100 хүртэл хувиар тооцож урамшуулах нь зүйтэй"- тай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үр дүнгийн урамшууллыг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан дүгнэж олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	1	2.3			1	2.3	1	2.3				
Дүн	1	2.3			1	2.3	1	2.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/ сая төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн сургалт	5	8.4	1	0.7	4	7.7						